



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/09/-НА-СТА-ААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	
3.8 Аудитын гол асуудал	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



“АЛТАЙ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ”
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.НАРАНЧИМЭГ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 167

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилчдын цалинг илүү олгосон, гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөх үндсэн болон түрээсийн төлбөрийг төлүүлээгүй, Хөгжлийн банктай байгуулсан гэрээний дагуу төлөх үндсэн төлбөрийг төлөөгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй, тайлант хугацаанд и баримтгүй худалдан авалт хийсэн, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөөгүй зэрэг нийт 1,719.2 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн 29.1.1 дэх заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020457

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,417,094,033.53	7,362,744,055.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	405,750,268.98	1,085,977,749.41
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	434,981.00	0
31110	Төгрөг	434,981.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	405,315,287.98	1,085,977,749.41
31210	Төгрөг	405,315,287.98	1,085,977,749.41
31213	Арилжааны банк дахь харилцах	405,315,287.98	1,085,977,749.41
33	АВЛАГА	6,670,352,754.55	5,955,775,295.67
33401	Дансны авлага /ТӨҮГ/	6,210,552,328.83	5,496,239,589.83
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	264,719.88	0
33500	Бусад авлага	459,535,705.84	459,535,705.84
33510	Байгууллагаас авах авлага	459,535,705.84	459,535,705.84
35	БАРАА МАТЕРИАЛ	991,010.00	991,010.00
35400	Хангамжийн материал	991,010.00	991,010.00
35420	Аж ахуйн материал	991,010.00	991,010.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	340,000,000.00	320,000,000.00
36900	БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	340,000,000.00	320,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,153,653.75	24,723,799.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,153,653.75	24,723,799.75
39200	Биет хөрөнгө	12,153,653.75	16,182,410.75
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,223,940.00	7,223,940.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-844,788.00	-1,554,576.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,223,790.00	12,093,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-449,288.25	-1,580,743.25
39300	Биет бус хөрөнгө	6,000,000.00	8,541,389.00
39301	Програм хангамж	0	2,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-188,611.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,435,247,687.28	7,387,467,854.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,293,770,697.99	7,187,687,896.85
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	613,213,618.99	507,130,817.85
41300	Өглөг	121,159.99	6,313,178.85
41360	Бусад өглөг	121,159.99	6,313,178.85
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	121,159.99	6,313,178.85
41400	Урьдчилж орсон орлого	613,092,459.00	500,817,639.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	166,637,212.00	166,637,212.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	446,455,247.00	334,180,427.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,680,557,079.00	6,680,557,079.00
42200	Урт хугацаат зээл	6,680,557,079.00	6,680,557,079.00
42210	Төгрөг	6,680,557,079.00	6,680,557,079.00
42243	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/	6,680,557,079.00	6,680,557,079.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	141,476,989.29	199,779,957.98
51	Засгийн газрын хувь оролцоо	141,476,989.29	199,779,957.98
51200	Хуримтлагдсан үр дүн	141,476,989.29	199,779,957.98
51210	Өмнөх үеийн үр дүн	4,491,909.20	141,476,989.29
51220	Тайлант үеийн үр дүн	136,985,080.09	58,302,968.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,435,247,687.28	7,387,467,854.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	228,056,712.51	165,391,242.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,056,712.51	165,391,242.17
120	Нийтлэг татварын бус орлого	228,056,712.51	165,391,242.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,317,424.00	19,881,422.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,317,424.00	19,881,422.17
120005	Түрээсийн орлого	90,967,665.00	90,255,335.00
120009	Бусад орлого	5,819,123.51	15,410,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	40,952,500.00	39,844,485.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	100,071,632.42	108,088,273.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,071,632.42	108,088,273.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,071,632.42	108,088,273.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,071,632.42	108,088,273.48
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	99,609,318.42	108,088,273.48
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	462,314.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	127,985,080.09	57,302,968.69
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	9,000,000.00	1,000,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	9,000,000.00	1,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	136,985,080.09	58,302,968.69

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,491,909.20	4,491,909.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,491,909.20	4,491,909.20
9	Тайлант үеийн үр дүн	136,985,080.09	136,985,080.09
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,476,989.29	141,476,989.29
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	141,476,989.29	141,476,989.29
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,476,989.29	141,476,989.29
19	Тайлант үеийн үр дүн	58,302,968.69	58,302,968.69
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	199,779,957.98	199,779,957.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	815,431,676.68	745,546,623.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	815,431,676.68	745,546,623.00
120	Нийтлэг татварын бус орлого	815,431,676.68	745,546,623.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	721,629,830.46	651,946,394.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	711,384,830.46	651,946,394.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,245,000.00	0
120005	Түрээсийн орлого	14,570,000.00	83,475,229.00
120009	Бусад орлого	6,317,923.26	10,125,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	72,913,922.96	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,623,448.06	97,600,564.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,623,448.06	97,600,564.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,623,448.06	97,600,564.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,397,961.00	61,154,027.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	58,397,961.00	61,154,027.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,925,298.57	15,758,560.04
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	14,925,298.57	15,758,560.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,820,216.95	5,395,378.82
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	3,820,216.95	5,395,378.82
2104	Хангамж, бараа материалын зардал	1,867,404.00	149,975.00
210401	Бичиг хэрэг	507,760.00	0
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	149,975.00

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	967,674.00	0
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	41,970.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	721,500.00	0
210604	Урсгал засвар	721,500.00	0
2107	Томилолт, зочны зардал	913,900.00	0
210702	Дотоод албан томилолт	913,900.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,977,167.54	15,142,623.88
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	8,989,662.80	0
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	6,198,321.49	7,497,027.88
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	20,789,183.25	7,645,596.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	698,808,228.62	647,946,058.26
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	159,317,424.00	40,881,422.17
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	69,000,000.00	21,000,000.00
140007	Хүлээн авсан хүүний орлого	90,317,424.00	19,881,422.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,616,151,095.84	8,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,616,151,095.84	8,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,616,151,095.84	8,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	8,600,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	6,615,390.00	0
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	1,609,535,705.84	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,456,833,671.84	32,281,422.17
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-758,025,443.22	680,227,480.43
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,163,775,712.20	405,750,268.98
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	405,750,268.98	1,085,977,749.41

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Орон сууцны борлуулалтын орлого	40,952,600.00	39,844,485.00	1,108,115.00	97
Түрээсийн орлого /орон сууц	65,200,000.00	72,430,335.00	-7,230,335.00	111
Дулаан зогсоолын түрээсийн орлого	12,000,000.00	17,825,000.00	-5,825,000.00	149
Граж борлуулсны үнийн зөрүү	0.00	1,000,000.00	-1,000,000.00	
Хадгаламжийн болон харилцах дансны хүүгийн орлого	5,200,000.00	19,881,422.17	-14,681,422.17	382
Бусад орлого	25,000,000.00	15,410,000.00	9,590,000.00	62
Сууц эзэмшигчийн үйлчилгээний хураамж	6,768,000.00	0.00	6,768,000.00	0
НИЙТ ОРЛОГО	155,120,600.00	166,391,242.17	-11,270,642.17	107
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			0.00	
1.3 Нийт ашиг	155,120,600.00	166,391,242.17	-11,270,642.17	107
Үйл ажиллагааны зардал	139,224,700.00	101,610,166.48	37,614,533.52	73
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	139,224,700.00	101,610,166.48	37,614,533.52	73
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	15,895,900.00	64,781,075.69	-48,885,175.69	408
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	15,895,900.00	64,781,075.69	-48,885,175.69	408
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	15,895,900.00	64,781,075.69	-48,885,175.69	408
3.1 Орлогын татварын зардал	1,589,590.00	6,478,107.57	-4,888,517.57	408
4. Татварын дараах ашиг алдагдал	14,306,310.00	58,302,968.12	-43,996,658.12	408

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 9 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, “Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ байгуулагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд орон сууцны зээл нь 5 жил төлөгдөхөөр авлага үүсгэж байгаа тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт нийт хөрөнгө 7,435.2 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 148.7 сая төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт нийт хөрөнгө 7,387.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 147.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

“Солонго хорооллын 120 айлын орон сууцны барилгыг орон нутгийн өмчид хүлээн авах комисс томилох тухай” Аймгийн засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/584 тоот захирамжаар байгуулагдсан ажлын комисс Барилга хот, байгуулалтын яамны захиалгаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт баригдсан Солонго хорооллын 2 блокийн 6 давхар тус бүр нь 60 айлын хүчин чадалтай нийт 120 айлын орон сууц, 40 автомашины дулаан зогсоол бүхий 5,453.8 м² талбайтай, 7,830.5 сая төгрөгийн үнэтэй орон сууцны барилга, дулаан зогсоолын хамт 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авчээ.

Солонго хорооллын 120 айлын орон сууцыг борлуулах, түрээсээр өмчлүүлэх ажлыг зохион байгуулахдаа Монгол Улсын Иргэний хууль, Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд сонгон шалгаруулж хамруулах комиссын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 04 тоот шийдвэрээр сонгон шалгаруулжээ. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор баталсан орон сууцны ашигтай талбайн 1м²-ийг 1.4 сая төгрөгөөр үнэлж гэрээ байгуулж түрээсийн орон сууцанд оруулан дараах нөхцөлөөр гэрээ байгуулжээ. Үүнд:

- Урьдчилгаа 30 ба түүнээс дээш хувийг төлөөд 5 жилийн хугацаанд бүрэн төлөх
- 30% хүртэл төлөөд 5 жилийн хугацаанд тэнцүү хэмжээгээр бүрэн төлөх
- 3 сарын барьцаа төлбөр, 1 сарын түрээс төлөөд 5-н жилийн хугацаанд тэнцүү хэмжээгээр төлөх
- 3 сарын барьцаа төлбөр, 1 сарын түрээс төлөөд 5 жилийн хугацаанд 30%-ийг тэнцүү бүрдүүлээд 5 жилийн дараа банкны зээлд хамрагдан төлөх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Алтай орон сууцны корпораци” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмчийн эзэмшилтэй байна.

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал, түрээс
Байгууллагын эрхэм зорилгыг “Төв суурин газарт амьдардаг нийт өрхийн дийлэнх олонхын худалдан авах чадварт нийцсэн, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 84 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг орон нутаг тухайн шатны ИТХ хэрэгжүүлэхээр заасан. Байгууллагын ажилчдын цалингийн жишгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд шилжүүлэн авсан бүх хөрөнгийг бүртгэл тооцоонд тусгаж, арчлалт, хадгалалт, хамгаалалтыг хийх арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу энэ төрлийн зардал гаргаагүй.

Харин Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.4-т “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, 1.5-т “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;”-д заасныг зөрчил албан конторын тавилга, сургалтын хоолны зардал гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн 30 дугаар тогтоолоор “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын бүтэц, албан тушаалын тодорхойлолт, цалингийн жишгийг шинэчлэн баталсан.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн, санхүүгийн тайлагналын алдаа зөрчлийг аудитын явцад залруулж тайлагнасан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	405.7	1,085.9	680.2
Авлага	6,670.4	5,955.8	-714.6
Бараа материал	1.0	1.0	0

Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө	340.0	320.0	-20.0
Үндсэн хөрөнгө	18.1	24.7	6.6
Нийт хөрөнгийн дүн	7,435.2	7,387.5	-47.7
Өр төлбөрийн дүн	7,293.8	7,187.7	-106.1
Богино хугацаат өглөг	613.2	507.1	-106.1
Урьдчилж орсон орлого	613.1	500.8	-112.3
Урт хугацаат өглөг	6,680.5	6,680.5	0
Эздийн өмч	141.4	199.8	58.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,435.2	7,387.5	-47.7

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, өглөг, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ нь Төрийн банк, ХААН банканд орон сууцны сан бүрдүүлэх данс, үйл ажиллагааны данс нээлгэсэн. Түрээсийн орон сууцны сангийн дансанд иргэдийн гэрээний дагуу 3 сарын барьцаа төлбөр 166.6 сая төгрөг байршиж санхүүгийн тайланд түрээсийн төлбөрийн барьцааны урьдчилж орсон орлогоор тайлагнагдсан байна.

Тайлант хугацаанд харилцах болон кассын дансанд түрээсийн орон сууцны үндсэн төлбөрөөс 651.9 сая төгрөгийг, орон сууцны болон зогсоолын түрээс 83.4 сая төгрөг, сууц өмчлөгч болон бусад орлогоос 10.1 сая төгрөгийг оруулсан. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,085.9 сая төгрөг болж 680.6 сая төгрөгөөр өссөн нь Хөгжлийн банканд орон сууцны зээлийн гэрээний дагуу хуваарьт төлбөрийг төлөөгүйтэй холбоотой.

Солонго хорооллын 2 блокийн 6 давхар тус бүр нь 60 айлын хүчин чадалтай нийт 120 айлын орон сууц, 40 автомашины дулаан зогсоол бүхий 5,453.8 м² талбайтай, 7,830.6 сая төгрөгийн үнэтэй орон сууцны барилга, дулаан зогсоолоос 7,470.5 сая төгрөгийн хөрөнгийг иргэдтэй гэрээ хийн авлагаар тайлагнасан байна. Нийт 40 зогсоолоос 8 зогсоолыг зарж борлуулсан бөгөөд 320.0 сая төгрөгийн 32 зогсоолыг санхүүгийн тайланд борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэжээ.

Авлага дансны үлдэгдэл 5,955.8 сая төгрөг болж 714.6 сая төгрөгөөр буурсан нь гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөх үндсэн болон түрээсийн төлбөрийг төлүүлсэнтэй холбоотой.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолоор “Хөгжлийн банканд төлөгдөх зээлийн хүүгийн төлбөр болох 1,435.6 сая төгрөгийг улс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс төлж барагдуулах”-ыг аймгийн Засаг даргад даалгасан боловч Хөгжлийн банканд орон сууцны төлбөрийн хүүд 459.5 сая төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөнтэй холбоотой авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын тодруулгад 1.0 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.7 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 8.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, элэгдэл тооцсон.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 507.1 сая төгрөг болж 106.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд урьдчилж орсон орлогыг тайлант хугацааны орлогоор тайлагнасантай холбоотой.

Хөгжлийн банкнаас орон сууцны ашигтай талбайн хэмжээг 1м²-ийг 1.36 сая төгрөгөөр тооцсон боловч иргэдэд 1.4 сая төгрөгөөр борлуулснаар талбайн үнийн зөрүү 204.7 сая төгрөгийн орлогыг урьдчилж орсноор тайлагнажээ. Үүнээс 2019 онд 6.8 сая төгрөгийг, 2020 онд 40.9 сая төгрөгийг, 2021 онд 39.8 сая төгрөгийг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч үр дүнгийн тайланд бүртгэсэн.

Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 25 тоот тушаалаар 1м2 талбайн түрээсийн төлбөрийг орон нутагт 0.0045 сая төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. Засгийн газрын 2019 оны 139 дүгээр тогтоолоор “түрээслэгч нь түрээсэлж байгаа орон сууцаа өмчлөх зорилгоор 5 хүртэлх жилийн хугацаанд түрээсийн төлбөрөөс гадна нэмэлт төлбөр төлж хуримтлуулан тухайн орон сууцны үнийн дүнгийн 30 хувийг төлсөн тохиолдолд орон сууцны зээлд хамрагдан түрээсийн орон сууцаа худалдан авч өмчлөх тохиолдолд түрээсийн сарын төлбөрийг 25 хувь байхаар тооцох”-оор заажээ. Түрээслэгчдээс 5 жилийн хугацаанд нийт 365.9 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг авахаар гэрээ байгуулсны дагуу санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор тайлагнасан. Тайлант хугацаанд 72.4 сая төгрөгийг түрээсийн орлогоор хүлээн зөвшөөрч үр дүнгийн тайланд бүртгэлээ.

Орон сууц, зогсоолын үнэ болох 7.830.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд төлөхөөр урт хугацаат өглөгийг тайлагнасан. Үүнээс 2020 онд 1,150.0 сая төгрөгийг төлж 6,680.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Харин 2021 оны гэрээний үнийг төлөх хуваарийн дагуу эргэн төлөлт хийгээгүй байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 199.8 сая төгрөг болж 58.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ашигтай ажилласантай холбоотой.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 155.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 139.2 сая төгрөгөөр, ашиг 15.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 166.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 101.6 сая төгрөгийн зардал гарган, 64.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 166.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 11.3 сая төгрөг буюу 7.2 хувиар давсан нь харилцах дансанд байршиж байсан мөнгөнөөсөө хадгаламжийн данс нээснээр хүүгийн орлого нэмэгдсэн, мөн дулаан зогсоолын түрээсийн орлогыг оруулсан нь нөлөөлсөн.

Нийт зардлын гүйцэтгэл 101.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 37.6 сая төгрөгийг хэмнэсэн буюу 73.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд 64.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөснөөс 48.8 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн, зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 570.6 сая төгрөгийн орлого, 1,125.0 сая төгрөгийн зарлага, 6,680.6 сая төгрөгийн өглөг, 5,955.8 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гүйлгээ бүрд төлбөрийн баримтаар буюу и баримт шивүүлж баримтын бүрдэл болгох үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ И-баримтгүй 2.2 сая төгрөгийн гүйлгээ хийснээс аудитын явцад 1.4 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэхгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 1,826.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 748.6 сая төгрөгийг алдааг залруулж, 128.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 143.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 805.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг өгсөн байна.

Өгсөн шийдвэрээс гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөх үндсэн болон түрээсийн 20.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй. Орон сууцны талбайн хэмжээ өөрчлөгдсөн байхад орон сууц түрээслэх гэрээний төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулаагүй, орон сууцны зээл төлөх хөрөнгийн эх үүсвэр дутагдах, Хөгжлийн банканд төлөх орон сууцны зээлийн хүүг төлөх хөрөнгийн эх үүсвэрийг хууль эрх зүйд нийцүүлэн шийдвэрлэх асуудлын хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орон тоо, цалингийн зардал, И баримтын бүрдэл, татварын тооцоолол, өр авлагын барагдуулалт, түрээслэх гэрээний төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан эсэх, зогсоолын түрээсийн гэрээ, авлага, өглөгийн тооцоо, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьсан байдлыг авч үзэх, мөн хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийх хэрэгтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,214.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 285.1 сая төгрөгийн алдааг залруулж, 210.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,719.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 283.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 1.4 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

4.2 Төлбөрийн акт

Ажилчдад 0.4 сая төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Үндсэн хөрөнгөнөөс 0.5 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөх үндсэн болон түрээсийн төлбөрөөс 208.4 сая төгрөгийг төлүүлээгүй нь Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Иргэдээс зогсоолын төлбөр 0.7 сая төгрөгийг, сууц эзэмшигчдийн хураамж 0.6 сая төгрөгийг дутуу төлүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Хөгжлийн банктай хийсэн гэрээний дагуу 2021 онд орон сууцны үндсэн төлбөрт 1,670.1 сая төгрөг, хүүд 375.7 сая төгрөгийг төлөөгүй, гэрээний дагуу алданги тооцогдохоор байгаа нь Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2.3-т "Худалдан авагч зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнийг Гэрээний Хавсралт 2-т тусгасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар тооцож, алданги ногдуулна" гэж заасантай нийцээгүй, нийцсэн

бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланд орлогыг 46.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан орон тоог 4 орон тоогоор хэтрүүлэн ажиллуулсан нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бүтэц, албан тушаалын тодорхойлолт, цалингийн жишгийг шинэчлэн батлах тухай 30 дугаар тогтоол"-той нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас 0.8 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчиж 1.1 сая төгрөгийн тавилга худалдан авч, сургалтын хоолны зардалд 0.2 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-т "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.5-т "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 570.6 сая төгрөгийн орлого, 1,125.0 сая төгрөгийн зарлага, 6,680.6 сая төгрөгийн өглөг, 5,955.8 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн

дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлангийн засгийн газрын хувь оролцоо дүнгээс 7,435.3 сая төгрөгөөр зөрүүтэй нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй”, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2-т “Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 8.2.3-т “хувь нийлүүлсэн хөрөнгө” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг дарга нь "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай хийсэн гэрээг жилийн эцэст дүгнэж цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлээгүй.
- 1.2. Аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмж: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан "Алтай орон сууцны корпораци аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 7.1-т "Аймгийн Засаг дарга нь "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой асуудал

- 2.1 Илрүүлэлт: Тайлант онд санхүүгийн программ авсан боловч программаараа тайлангаа гаргаагүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг программаар гаргаж, стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ	12	2,212.6	1	283.7	3	210.5	5	1,718.4	2	0
Дүн		12	2,212.6	1	283.7	3	210.5	5	1,718.4	2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ	2	2.2		1.4			2	0.8	0	0
Дүн		2	2.2					2	0.8	0	0
Нийт дүн		14	2,214.8	1	285.1	3	210.5	7	1,719.2	2	0